



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар A/16

Улаанбаатар хот

Г Баримтлах чиглэл батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрхэзүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсад нам орбитын хиймэл дагуулын сүлжээ ашиглахад баримтлах чиглэл”-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Дээрх баримтлах чиглэлийн хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газрын дарга /З.Гантоогоо/-д үүрэг болгосугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД БӨГӨӨД ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН
ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ

Д.ЭНХ-АМГАЛАН



Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
20~~99~~ оны ~~04~~ дугаар сарын ~~.../...~~ -ны өдрийн
~~11/6~~ дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД НАМ ОРБИТЫН ХИЙМЭЛ ДАГУУЛЫН СҮЛЖЭЭ АШИГЛАХАД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү баримт бичгийг Монгол Улсад нам орбитын хиймэл дагуулын сүлжээг харилцаа холбооны системийн дамжуулах сүлжээнд ашиглахад баримтална.

Хоёр. Бодлого, зохицуулалтын орчин

2.1. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх) нь Дэлхийн радио холбооны их хурлаар батлагдсан болон бэлтгэл хурал, Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ОУЦХБ)-ын судалгааны ажлын хэсгийн хүрээнд судалж байгаа нам орбитын хиймэл дагуулын сүлжээнд ашиглах радио давтамжийн зурвасыг төлөвлөх, дахин төлөвлөх, нөөцийг бүрдүүлэх, зохицуулалт хийх арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллана.

2.2. Нам орбитын хиймэл дагуулын дамжуулах сүлжээг ашиглан алслагдсан бус нутаг буюу харилцаа холбооны дэд бүтэц, сүлжээ хүрээгүй газарт тоон хуваагдлыг бууруулах, гамшгийн үеийн харилцаа холбооны систем, тоон дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлийг баримтална.

2.3. Нам орбитын хиймэл дагуулын сүлжээг ашиглах зөвшөөрөл нь сансрын холбооны сүлжээ байгуулах, эзэмших, ашиглах тусгай зөвшөөрлийн ангилалд хамаарна.

2.4. Нам орбитын хиймэл дагуулын дамжуулах сүлжээг ашиглахад Зохицуулах хороо дараах нөхцөлийг бүрдүүлнэ:

2.4.1. Олон улсын болон бүсийн стандартчиллын байгууллагаас баталсан нам орбитын хиймэл дагуулын сүлжээний газрын станцын болон хүлээн авах төхөөрөмжид тавигдах норм норматив, техник, технологийн нөхцөл шаардлагад нийцүүлэн зохицуулалтын баримт бичигт холбогдох өөрчлөлтийг тусгах, батлах;

2.4.2. нам орбитын хиймэл дагуулын сүлжээнд ашиглах радио давтамжийн эрхийн болон ашиглалтын төлбөр, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, түүнтэй холбогдох харилцааг хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх;

2.4.3. нам орбитын хиймэл дагуулын радио төхөөрөмжийг баталгаажуулах, баталгаажсан хэрэглэгчийн төхөөрөмж бүрд тохирлын тэмдэг, дугаар олгох;

2.4.4. Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль болон Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт, Радио давтамжийн

хуваарилалтын дунд хугацааны төлөвлөлт (2020-2025 он)-ийн дагуу нам орбитын хиймэл дагуулын сүлжээнд ашиглах радио давтамжийг төлөвлөх, хуваарилах, олгоход ил тод байх, нээлттэй мэдээлэх, тэгш хандах зарчмыг баримтлах.

Гурав. Нам орбитын хиймэл дагуулын сүлжээний ашиглалт

3.1.Нам орбитын хиймэл дагуулын сүлжээ нь Олон улсын болон бусийн стандартчиллын байгууллагаас баталсан стандартыг хангасан байна.

3.2.Монгол Улсад нам орбитын хиймэл дагуулын сүлжээг зөвхөн дамжуулах сүлжээг зохион байгуулахад ашиглана.

3.3.Дэлхийн радио холбооны дүрмийн үндсэн зарчмын дагуу ашиглаж байгаа радио давтамжийн зурваст хамгийн сүүлийн үеийн техникийн дэвшлийг ашиглах чиглэлийг баримтална.

3.4.Нам орбитын хиймэл дагуулын сүлжээг ашиглах хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

3.4.1.интернэтийн харилцан холболтын тоног төхөөрөмжийг Монгол Улсад байршуулах;

3.4.2.интернэт урсгалыг “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг “Мэдээлэл холбооны сүлжээ” төрлөөр, “Үндсэн сүлжээ (Улс хооронд)” хамрах хүрээтэйгээр авсан тусгай зөвшөөрөл эзэмшигчээс түрээслэх;

3.4.3.нам орбитын хиймэл дагуулын сүлжээний дамжуулах, чиглүүлэх, хүлээн авах байгууламжийн удирдлага, хяналтын системийг Монгол Улсад байршуулж, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжиж байгаа мэдээллийн урсгалыг энэхүү удирдлага, хяналтын системээр дамжуулах;

3.4.4.нам орбитын хиймэл дагуулын сүлжээ хооронд, нам орбитын хиймэл дагуулаас геостационар (GSO) орбитын хиймэл дагуулд, нам орбитын хиймэл дагуулаас бүх төрлийн харилцаа холбооны газрын сүлжээнд болон одон орон судлалын үйл ажиллагаанд радио долгионы интерференц үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх.

3.5.Радио долгионы зөвшөөрөгдөөгүй интерференц үүссэн тохиолдолд нам орбитын хиймэл дагуулын сүлжээг ашиглах хуулийн этгээд нь хиймэл дагуулын олон улсын болон үндэсний радио давтамжийн координаци хийж интерференцийг арилгана. Шаардлагатай тохиолдолд Дэлхийн радио холбооны дүрмийн дагуу ОУЦХБ, Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Зохицуулах хороо болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

3.6.Нам орбитын хиймэл дагуулын сүлжээг ашиглах хуулийн этгээд нь нам орбитын хиймэл дагуулын сүлжээний ашиглалт, тогтвортой ажиллагаа, үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлийн тусгай

зөвшөөрөлтэй этгээдтэй нээлттэй, үл ялгаварлах зарчмыг баримтлан хамтран ажиллана.

3.7. Монгол Улсад онц болон дайны байдал зарласан, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд бүх нийтийн үйлчилгээний үргийн болон үндэсний аюулгүй байдлыг хангах зориулалтаар харилцаа холбооны үйлчилгээ үзүүлж болно.

Дөрөв. Бусад

4.1. Энэхүү бодлогын чиглэлийн баримт бичигт техник, технологийн хөгжил, олон улсын болон үндэсний холбогдох баримт бичгүүдэд өөрчлөлт орсонтой холбоотойгоор тухай бүрд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

---oo---